




МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГЫН
АЛБА ХААГЧИЙН ГУТАЛ.

ТЕХНИКИЙН ШААРДЛАГА



АЛБАН ХЭВЛЭЛ

СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР
УЛААНБААТАР ХОТ
2018 ОН

Өмнөх үг

Стандарт, хэмжил зүйн газар (СХЗГ) нь Олон улсын стандартчиллын байгууллагын гишүүн бөгөөд үйл ажиллагааныхаа хүрээнд төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран үндэсний стандартчиллын бодлогыг хэрэгжүүлэх ажил эрхэлдэг.

Стандартын төсөл боловсруулах ажлыг салбарын стандартчиллын Техникийн хороо (ТХ), Дэд хороо (ДХ) эрхлэн гүйцэтгэдэг бөгөөд Техникийн хорооны хурлаар хэлэлцэж 75%-иас доошгүй дэмжиж зөвшилцсөн төслийг Стандартчиллын, үндэсний зөвлөл (СҮЗ)-өөр хэлэлцэн, тогтоолоор баталснаар хүчин төгөлдөр болно.

Энэхүү стандартыг ШУТИС-ийн Үйлдвэрлэлийн технологийн сургуулийн Хөнгөн үйлдвэрлэлийн технологи инженерчлэлийн салбарын багш Б.Батдулам, эрдэм шинжилгээний ажилтан Б.Цацрал, профессор Л.Удвал, “Аюулгүй хөдөлмөрийн үндэс” НҮТББ-ийн зөвлөх, доктор Д.Энхжаргал, Гамшиг судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан А.Ариунбилэг нар боловсруулж, СХЗГ-ын мэргэжилтэн Ч.Пүрэвдулам “Монгол улсын стандартчиллын тогтоолын 2-р хэсэг: “Стандартын бүтэц ба боловсруулах дүрэм MNS 1-2:2006” стандартад нийцүүлэн засварлав.

Уг стандартыг Текстилын техникийн хороогоор хэлэлцэн дэмжсэн болно.

Стандарт, хэмжилзүйн газар (СХЗГ)

Энхтайваны өргөн чөлөө 46А
Улаанбаатар 13348, ШХ-48
Утас: 266754, 263860,
Факс: (976-11) 458032
E-mail: standardinform@masm.gov.mn
Вэб сайт: www.estandart.mn,
www.masm.gov.mn

© СХЗГ, 2018

“Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай” Монгол улсын хуулийн дагуу энэхүү стандартыг бүрэн эсвэл хэсэгчлэн хэвлэх, олшруулах эрх нь гагцхүү СХЗГ (Стандартчиллын төв байгууллага)-т байна.

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалын код: 61.060

Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн гутал.
Техникийн шаардлага
Staff footwear of the “National Emergency Management Agency”. Technical requirement

MNS 6708:2018

Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2018 оны 4 дүгээр сарын 26-ний өдрийн 08 дугаар тогтоолоор батлав.

Энэхүү стандартыг улсын бүртгэлд бүртгэсэн өдрөөс эхлэн мөрдөнө.

Зорилго

Энэхүү стандартын зорилго нь Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн өмсөх гутлын материалын чанарын үзүүлэлтүүд, түүнд тавих шаардлагыг тогтооход оршино.

1. Хамрах хүрээ

Энэхүү стандарт нь Онцгой Байдлын Байгууллагын алба хаагчийн ажлын гутлыг үйлдвэрлэх, чанар шалгах, шалган хүлээн авах, хадгалах тээвэрлэхэд хамаарна.


2. Норматив ишлэл

Энэхүү стандартад дараах иш татсан стандарт, баримт бичгүүдийг хэрэглэсэн бөгөөд иш татсан стандартад өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлчийн албан ёсны эх материалыг ашиглана. Үүнд:

- ISO 20344:2004 Хувийн хамгаалах хэрэгсэл-Гутлын туршилтын аргууд,
- ISO 20346:2004 Хувийн хамгаалах хэрэгсэл-Хамгаалалтын гутал,
- ГОСТ 16993:71 Гутал. Жингийн норм,
- MNS 2997:1985 Гутлын нэр томьёо тодорхойлолт,
- MNS 0098:1982 Гутал. Чанарын суурь үзүүлэлт,
- MNS 0078:1988 Гутал. Ерөнхий техникийн шаардлага,
- MNS 5623:2006 Хөлний хамгаалалт. Ажлын тусгай гутал,
- MNS 4931:2000 Хөдөлмөрийн хамгаалах хэрэгсэл. Ерөнхий шаардлага ангилал,
- MNS 0084:2002 Гутлын дээд биений болон дотрын зориулалттай боловсруулсан арьс. Техникийн шаардлага,
- MNS 0176:1988 Гутал, Лабораторийн сорилт туршилтын аргууд, Дээж авах журам,
- MNS 81-2:2008 Арьс шир. Гутлын улны хөх шир. Техникийн шаардлага,
- MNS 0526:2009 Арьс шир. Боловсруулсан үслэг нэхий. Техникийн шаардлага.

3. Нэр томьёо, тодорхойлолт

Стандартад дараах тодорхойлолт бүхий нэр томьёо ашигласан болно.



3.1**Ажлын тусгай гутал**

Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн ажлын гутал-Механик биет, химийн бодис, ус чийг, онцгой нөхцөлд тохиолдож болзошгүй осол гэмтлээс хөлийг хамгаалах, хүний эрүүл мэндэд тохирсон зориулалтын хэрэгсэл

3.2 Гутлын нэр төрөл**3.2.1****хагас түрийтэй ботинк**

хөлийн тавхайг бүтэн бүрхсэн, шагай хүртэлх өндөр түрийтэй гутал

3.2.2**ботинк**

хөлийн тавхай ба шагайнаас дээш нарийн шилбэ хүртэлх өндөр түрийтэй гутал

3.2.3**хагас түрийтэй гутал**

хөлийн тавхай ба нарийн шилбийг бүтэн бүрхсэн бүдүүн булчин хүртэлх өндөр түрийтэй гутал

3.2.4**урт түрийтэй гутал**

хөлийн тавхай ба бүдүүн булчинг бүтэн бүрхсэн өвдөг хүртэлх өндөр түрийтэй гутал

3.3 Гутлын материал**3.3.1****Хром**

хромын суурилаг давсаар идээлж, дүүргэлт тосолгоо хийж, өнгө засал хийсэн үхэр, адууны шир

3.3.2**юфть (бухаар)**

хром болон ургамлын идээлгээр хийсэн их хэмжээгээр тослогдсон будагтай эсвэл байгалийн өнгөөр нь боловсруулсан арьс

3.3.3**нубук**

хром, ургамлын идээлэгтэй өнгө талаас цэлмэнжүүлсэн арьс

3.3.4**илэг**

хром, ургамлын идээлэгтэй шар махан талаас нь зүлгэж цэлмэнжүүлсэн арьс

3.3.5**гутлын дотрын зориулалттай арьс**

хром, ургамлын идээлэгтэй будагтай эсвэл байгалийн өнгөөр нь боловсруулсан арьс

3.3.6**3.3.7****гутлын зориулалттай даавуу**

гутлын түрийний эд ангид зориулагдсан нэхмэл материал

3.3.8**улны резин**

гутлын улны зориулалтаар каучук болон бусад бүрэлдэхүүн бүхий холиогоор хийгдсэн нийлэг материал

3.3.9**шахмал шир**

арьсны өөдөс, зоргодос, хүрэн ширний захалгаа зэргийг дахин задлаж жижигрүүлж, наагч бодисын тусламжтайгаар нягтруулан шахаж үйлдвэрлэсэн материал

3.3.10**улны шир**

үхрийн хүнд жингийн том шириийг ургамлын болон нийлэг идээгээр идээлж боловсруулсан хатуу нягт шир

3.4 Гутлын эд анги**3.4.1****толгойн өнгө**

тавхайн халз хэсгийг бүрхсэн гутлын дээд эд анги

3.4.2**түрийний өнгө**

хөлийн бүдүүн шилбэ зарим тохиолдолд түүнээс дээш хэсгийг бүрхсэн гутлын дээд хэсгийн өнгөний эд анги

3.4.3**түрийний дотор**

хэлбэр, хэмжээгээрээ түрийний өнгөтэй тохирох гутлын дээд хэсгийн дотор эд анги

3.4.4**толгойн дотор**

хэлбэр хэмжээгээрээ гутлын толгойн өнгөтэй тохирох гутлын дээд хэсгийн дотор эд анги

3.4.5**хэл**

хагас түрийтэй ботинк, хагас түрийтэй гутлын түрийн урд байрлах гуурс, дэгээний даралтаас хөлийг хамгаалах зориулалттай өнгөн эд анги

3.4.6**битүү хэл**

хагас түрийтэй гутлын түрийн урд байрлах гуурс, дэгээний даралт, тоос шорооноос хөлийг хамгаалах зориулалттай, түрийтэй залгаа оёгдсон өнгөн эд анги

3.4.7**гуурсан давхарга**

гуурсны бэхэлгээг сайжруулах зориулалттай эд анги

3.4.8**зөөлөвч**

түрийн кант хэсэгт байрлах эд анги

3.4.9**түрийний цаваг**

гутлын дээд хэсгийн хэлбэрийг бэхжүүлэх суналтаас хамгаалах бөх бат чанарыг сайжруулах зориулалт бүхий дотор эд анги

3.4.10**хамрын хатуулга**

гутлын хамар хэсэгт байрлах түүний хэлбэр дүрсийг хадгалах зориулалттай завсрын эд анги

3.4.11**зуузайн хатуулга**

гутлын түрий хэсэгт байрлаж түүний хэлбэр дүрсийг хадгалах зориулалттай завсрын эд анги

3.4.12**дэвсгэр улавч**

гутлын дотор талын эрүүл ахуй гоо зүйн шаардлагыг хангах дотуур улны жигд биш гадаргуугаас хөлийг хамгаалах зориулалттай хөлийн тавхайтай шууд харьцах дотор эд анги

3.4.13**тусгаарлагч ул**

гутлын улны хэсэгт байрлах, 1100Н-оос багагүй хүчийг тэсвэрлэх завсарын эд анги

3.4.14**дотуур ул**

гутлын түрийг хэлбэж бэхлэх дэвсгэр улавч гадуур улны хооронд байрлах эд анги

3.4.15**гадуур ул**

газартай шууд харьцаж үрэлт, нугаралт зэрэг ачаалалд өртдөг гутлын улны өнгөний эд анги

3.5 Гутлын бөх батын тодорхойлолт**3.5.1****гутлын уян нугарамхайшил**

тогтоосон нөхцөлд гутлын нугарах чадвар

3.5.2**оёоны бэхэлгээний бөх бат**

тогтоосон нөхцөлд оёдлыг ханзлахад зарцуулагдах хүч

3.5.3**улалгааны бөх бат**

тогтоосон нөхцөлд гутлын улыг ханзлахад зарцуулагдах хүч

3.5.4**өсгийн бэхэлгээний бөх бат**

тогтоосон нөхцөлд гутлын өсгийг ховхлоход зарцуулагдах хүч

4 Ангилал

4.1 Онцгой Байдлын Байгууллагын алба хаагчийн гутлыг дараах байдлаар ангилна. Үүнд:

Хүйсээр нь:

1. Эмэгтэй
2. Эрэгтэй

Улирлаар нь:

1. Дулааны
2. Хүйтний

Материалын нэр төрлөөр нь:

1. Арьс шир
2. Резинэн болон полимер

Гутлын нэр төрлөөр нь:

1. Хагас түрийтэй ботинк
2. Ботинк
3. Хагас түрийтэй гутал
4. Урт түрийтэй гутал

5 Ерөнхий шаардлага

5.1 Гутлын өнгө, загвар эрх зүйн баримт бичгээр батлагдсан байна.

5.2 Гутлын өмсгөл хэмжээ MNS 6343:2012 “Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын албан хаагчийн хувцасны ерөнхий ангилал, нэр төрөл, хэмжээ”, түрийний өндрийн хэмжээ EN ISO 20346:2004 стандартад заасантай тохирч байна (1-р хүснэгт).

Гутлын түрийний өндрийн хэмжээ

1-р хүснэгт

Өмсгөл хэмжээ		Өндөр			
Франц, штих	Метрийн систем, мм	Хагас түрийтэй ботинк, мм-ээс ихгүй	Ботинк, мм-ээс багагүй	Хагас түрийтэй гутал, мм-ээс багагүй	Урт түрийтэй гутал, мм-ээс багагүй
36-аас бага	225-аас бага	<103	>103	162	255
37-38	235-240	<105	>105	165	260
39-40	250-255	<109	>109	172	270
41-42	265-275	<113	>113	178	280
43-44	285-290	<117	>117	185	290
45-аас их	295-аас их	<121	>121	192	300

5.3 Гутал (өрөөсөн)-ын жин 2-р хүснэгтэд заасантай тохирч байна.

Гутлын жингийн үзүүлэлт

2-р хүснэгт

№	Гутлын нэр төрөл		Гутлын жин, гр-аас ихгүй, (өрөөсөн)
1	Эрэгтэй	Хагас болон урт түрийтэй гутал	900
2		Хагас түрийтэй ботинк болон ботинк	460
3	Эмэгтэй	Хагас болон урт түрийтэй гутал	530
4		Хагас түрийтэй ботинк болон ботинк	340

5.4 Хагас түрийтэй үдээстэй гутал нь битүү хэлтэй байна. Хагас болон урт түрийтэй (үдээсгүй) гутлын түрий нь өргөсгөх, нарийсгах зориулалтын нэмэлт эд ангитай байж болно.

5.5 Гуталд MNS 5623:2006 Хөлний хамгаалалт. Ажлын тусгай гутал стандартын 7-д заагдсан тусгай шаардлага тавигдана.

5.6 Гуталд тавигдах техникийн үзүүлэлт, бүтэц нь MNS 5623:2006 Хөлний хамгаалалт. Гутал стандартын 8-д заасан шаардлагатай нийцсэн байна.

5.7 Гутлын дээд болон дотрын зориулалттай боловсруулсан арьсны хими, физик, механикийн үзүүлэлтүүд 3-р хүснэгтэд заасан шаардлагыг хангасан байна.

Гутлын түрийний дээд болон дотрын зориулалттай боловсруулсан арьсны хими, физик, механикийн үзүүлэлт

3-р хүснэгт

№	Үзүүлэлт	Хром, нубук	Юфть,	Дотрын зориулалттай арьс	Үслэг Арьс	Илэг
1	Чийг, %	14				
2	Тос, %	5-10	5,5-12	5-10	5-8	5-10
3	Оксид хром, % багагүй	3,5				
4	Тасралт эсэргүүцэх даалт, Н/мм ² багагүй	25	25	12	10	25
5	Өнгөний язралт, Н/мм ² , багагүй	15	15	8	-	-
6	Харьцангуй суналт, %, багагүй	15	15	18	15	15
7	Будгийн тогтвор үрэлтэд, балл, -хуурай /20/ -нойтон /10/	4-5	4-5	5	4-5	4-5
		3-5	3-5		3-5	3-5
8	Хучих будгийн олон нугаралт тэсвэрлэх чадвар, удаа, багагүй	3000	2000	-	-	-
9	Ус нэвтрэлт, гр/цаг	0,5	0,35	-	-	-
10	Үлдэгдэл суналт, %, талбайгаар	5-15	5-12	-	-	5-15
11	Арьсны зузаан, мм	1,4-2,0	1,7-2,4	0,6-1,2	1,8-3,0	-

5.8 Халааж боловсруулах аргаар уллах гутлын дотуур ул ба түрийний эд ангийг өндөр температурт тэсвэртэй материалаар үйлдвэрлэнэ. Гутлын түрийний ба улны материал нь багадаа -30⁰С ба түүнээс дээш хүйтнийг тэсвэрлэх чадвартай байна.

5.9 Гутлын ус нэвтрэлтийн үзүүлэлтийн доод хэмжээ MNS0078:1988 Гутал. Ерөнхий техникийн шаардлага стандартын 2.7-д заасан үзүүлэлтийн шаардлагыг хангасан байна.

5.10 Гутлын уян нугарамхайшлийн үзүүлэлт нь 4-р хүснэгтэд заасан шаардлагатай тохирч байна.

Гутлын уян нугарамхайшлын үзүүлэлт

4-р хүснэгт

Гутлын төрөл	Улалгааны арга	Уян нугарамхайшил кгх /см-ээс багагүй			
		Улны шир	Шахмал резин	Хөвсгөр резин	Шахмал шир
Эрэгтэй хүний	Наалт	1,5	-	1,2	1,2
	Халааж боловсруулах	-	1,3	1,2	-
	Даралтаар цутгах	-	1,5	-	-
Эмэгтэй хүний	Наалт	1,1	1,1	1,0	-
	Халааж боловсруулах, даралтаар цутгах	-	1,1	0,9	-

5.11 Гутлын түрийний оёоны бөх батын үзүүлэлт нь 5-р хүснэгтэд заасан шаардлагатай тохирч байна.

Гутлын түрийний оёоны бөх батын үзүүлэлт

5-р хүснэгт

Материалын нэр	Үзүүлэлтийн доод хэмжээ, Н/см		
	Дан оёонд	Давхар оёонд	Хоёроос дээш оёонд
Бүх төрлийн хром, бухаар, булигаар, цэмбэ, бүх төрлийн даавуу	75,0	100,0	120,0

5.12 Гутлын улалгааны бөх батын үзүүлэлт нь EN ISO 20344:2004 Хувийн хамгаалах хэрэгсэл. Гутлын сорил туршилтын аргууд стандартын 5.2-д заасан үзүүлэлттэй тохирч байна.

5.13 Гутлын өсгийний бөх батын үзүүлэлт нь MNS 0078 Гутал. Ерөнхий техникийн шаардлага стандартын 4.11, шалгаж, хүлээн авахдаа 5-д заасантай тохирч байна.

6. Хаяглах, савлах, хадгалах, тээвэрлэхэд тавих шаардлага

6.1 Гутал хаяглалт буюу тэмдэглэгээ нь дараах мэдээллийг агуулсан байна. Үүнд:

- Өмсгөл хэмжээ,
- Барааны тэмдэг,
- Хүйс (эрэгтэй хүний М, эмэгтэй хүний F),

MNS 6708:2018

- Загварын дугаар,
- Үйлдвэрлэсэн огноо,
- Стандартын дугаар,
- Үйлдвэрлэсэн улсб

6.2 Гутлын хаяглалтыг савхи, зориулалтын туузан дээр хэвлэх, хатгаж оёх аргаар хийж, хэл болон түрийний дотор талд тод харагдахуйцаар оёж бэхлэсэн байна.

6.3 Барааны тэмдэгийг бүтэн ба хагас улавч, өсгийвч болон ширэн улны ивүүргийн хэсэгт дарна.

6.4 Бэлэн гутлыг хайрцаг савгүйгээр хадгалах тээвэрлэхийг хориглоно

6.5 Хайрцагтай гутлыг (40-60)%-ийн харьцангуй чийглэгтэй ердийн температуртай зориулалтын агуулахад нарны цацраг шууд тусахгүй дулааны эх үүсвэрээс 1 м-ээс багагүй зайтайгаар шалнаас (30-40) см-ийн өндөр вандан дээр хурааж хадгална.

ТӨГСӨВ.